

# НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/329/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
	Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: <a href="mailto:Otgonbayarda@audit.gov.mn">Otgonbayarda@audit.gov.mn</a>
	Б энд С аудит ХХК-ийн Захирал Д.Заяажаргал Утас:99050268 Цахим хаяг: <a href="mailto:info@bcauditllc.com">info@bcauditllc.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

№ 226-Ор. 25 № 362  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Ч.ӨНӨРСАЙХАН ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж, шалгагдагч байгууллагаас хараат бусаар ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй 989.2 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хосолсон систем буюу эмнэлгийн үндсэн хүчилтөрөгчийн шугамд 1 цагт 30,000 литр шахах, нөөцийн баллоны хэсэгт 1 цагт 40 литрийн 4-5 баллон цэнэглэх хүчин чадал бүхий хүчилтөрөгчийн үйлдвэрийг 560.0 сая төгрөгийн өртгөөр Ай мед технологис ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна. Мөн 4,693.0 сая төгрөгөөр барилгын их засварын ажлыг эмнэлгийн А корпус болон гадна фасад, цахилгаан шат шинээр суурилуулах зэрэгт хийж, ажлын гүйцэтгэл 95.0 хувьтай үргэлжилж байна.

C:\Users\narangua\Desktop\Баяр хэрг 2025\2025\1426050460.docx

1426050460

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

#### **Аудитын гол асуудал**

Үндсэн хөрөнгийн дансанд 1975 онд ашиглалтад орсон 54.2 мянган төгрөгийн анхны өртөгтэй элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, одоогоор иргэдэд ашиглуулж байгаа Баянгол дүүргийн 20 дугаар хороо Толгойт дахь хүүхдийн эмнэлгийн байрыг зориулалтын дагуу эзэмшиж ашигладаггүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 98 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг 90.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b><u>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</u></b>	<b>250,681,586.07</b>	<b>107,101,432.71</b>
Төрийн сангийн харилцах	250,681,586.07	107,101,432.71
<b><u>АВЛАГА</u></b>	<b>1,640,610,369.58</b>	<b>202,197,868.63</b>
Ажиллагчидтай холбогдсон авлага	2,383,610.79	
Төлбөртэй үйлчилгээний авлага	1,637,317,758.79	200,040,208.63
Бусад авлага	909,000.00	2,157,660.00
<b><u>УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР</u></b>	<b>-</b>	<b>10,540,000.00</b>
Урьдчилж гарсан зардал		10,540,000.00
<b><u>БАРАА МАТЕРИАЛ</u></b>	<b>2,924,694,811.67</b>	<b>2,838,836,043.97</b>
Түүхий эд материал	1,540,309,086.94	1,657,916,316.87
Эм боох материал	1,540,309,086.94	1,657,916,316.87
Хангамжийн материал	1,384,385,724.73	1,180,919,727.10
Бичиг хэрэг	12,587,730.00	9,684,903.00
Аж ахуйн материал	9,229,926.12	6,702,715.70
Сэлбэг хэрэгсэл	3,874,000.00	27,500.00
Түлш, шатах тослох материал	6,800,000.00	8,840,000.00
Барилгын засварын материал	2,588,400.00	579,850.00
Хүнсний материал	18,101,327.00	11,418,400.00
Бусад хангамжийн материал	1,331,204,341.61	1,143,666,358.40
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,815,986,767.32</b>	<b>3,158,675,345.31</b>
<b><u>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</u></b>		
<b><u>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</u></b>	<b>30,511,696,533.28</b>	<b>30,842,163,776.95</b>
<b><u>Биет хөрөнгө</u></b>	<b>29,959,392,798.02</b>	<b>30,291,015,469.54</b>
Барилга, байгууламж	24,825,725,396.51	27,421,055,867.51
Хуримтлагдсан элэгдэл	(5,554,739,213.13)	(6,016,517,692.62)
Авто- тээврийн хэрэгсэл	383,360,000.00	383,360,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(230,788,001.29)	(275,154,667.93)
Машин, тоног төхөөрөмж	16,392,303,740.16	16,136,725,443.76
Хуримтлагдсан элэгдэл	(6,185,656,060.35)	(7,685,988,304.03)
Тавилга, аж ахуйн эд хогшил	533,058,094.73	584,905,901.35
Хуримтлагдсан элэгдэл	(211,386,159.13)	(262,703,079.10)
Бусад үндсэн хөрөнгө	11,740,000.00	11,740,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(4,224,999.48)	(6,407,999.40)
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>	<b>552,303,735.26</b>	<b>551,148,307.41</b>
Программ хангамж	7,648,000.00	7,648,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(3,784,397.59)	(4,910,022.59)
Бусад	548,710,330.00	548,710,330.00
Хуримтлагдсан элэгдэл	(270,197.15)	(300,000.00)
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>30,511,696,533.28</b>	<b>30,842,163,776.95</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>35,327,683,300.60</b>	<b>34,000,839,122.26</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
<b>Өглөг</b>	<b>2,650,653,217.77</b>	<b>2,705,415,896.80</b>
Ажиллагчидтай холбогдсон өглөг	990,097,310.67	522,381,631.48

Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,660,555,907.10	2,183,034,265.32
Бусад өглөг	<b>549,526,080.54</b>	<b>295,962,923.65</b>
Байгууллагад төлөх өглөг	546,802,526.89	293,239,370.00
Хувь хүмүүст төлөх өглөг	2,723,553.65	2,723,553.65
<b><u>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</u></b>	<b>3,200,179,298.31</b>	<b>3,001,378,820.45</b>
<b><u>УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН</u></b>	-	-
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>3,200,179,298.31</b>	<b>3,001,378,820.45</b>
Засгийн газрын хувь оролцоо	32,127,504,002.29	30,999,460,301.81
Засгийн газрын оруулсан капитал	4,084,344,428.61	4,084,344,428.61
- төрийн	4,084,344,428.61	4,084,344,428.61
Дахин үнэлгээний нэмэгдэл	7,636,423,361.40	7,636,423,361.40
Хуримтлагдсан үр дүн	20,406,736,212.28	19,278,692,511.80
Өмнөх үеийн үр дүн	11,595,371,455.97	20,406,956,648.66
Тайлан үеийн үр дүн	8,811,364,756.31	(1,128,264,136.86)
<b><u>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН</u></b>	<b>32,127,504,002.29</b>	<b>30,999,460,301.81</b>
<b><u>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</u></b>	<b>35,327,683,300.60</b>	<b>34,000,839,122.26</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>		
<b><u>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u></b>	<b>14,537,342,230.17</b>	<b>14,593,681,471.37</b>
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>440,636,395.96</b>	-
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	440,636,395.96	
<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>14,096,705,834.21</b>	<b>14,593,681,471.37</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,096,705,834.21	14,593,681,471.37
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>15,704,583,027.53</b>	<b>6,622,026,091.82</b>
<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,240,727,681.47</b>	<b>1,937,444,369.36</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,054,542,777.47	986,258,929.70
Туслах үйл ажиллагааны орлого	186,184,904.00	951,185,439.66
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	10,825,943,093.08	2,795,073,541.10
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	2,000,594,494.19	1,689,467,972.73
<b>Тусламжийн орлого</b>	<b>1,637,317,758.79</b>	<b>200,040,208.63</b>
Хандив тусламж /дотоод/	1,637,317,758.79	200,040,208.63
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>30,241,925,257.70</b>	<b>21,215,707,563.19</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>		
<b><u>АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</u></b>	<b>11,138,337,974.73</b>	<b>11,354,087,653.98</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>9,897,823,937.07</b>	<b>10,082,584,378.57</b>
Цалин	6,321,875,712.56	6,348,638,261.42
Цалингийн тусгай нэмэгдлүүд	1,866,207,024.91	1,892,923,947.15
Унаа хоолны хөнгөлөлт	1,044,036,000.00	1,530,879,000.00
Урамшуулал	665,705,199.60	310,143,170.00
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>1,240,514,037.66</b>	<b>1,271,503,275.41</b>
Тэтгэврийн даатгал	852,485,937.60	871,983,350.39
Тэтгэмжийн даатгал	101,529,040.90	103,565,439.59
ҮОМШӨ-ний даатгал	64,630,166.84	71,313,287.85

Эрүүл мэндийн даатгал	177,680,389.68	180,801,266.29
Ажилгүйдлын даатгал	44,188,502.64	43,839,931.29
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>8,072,608,983.50</b>	<b>9,665,653,758.87</b>
Тогтмол зардал	<b>436,330,936.96</b>	-
Гэрэл цахилгааны зардал	215,113,051.57	
Түлш, халаалтын зардал	45,182,166.76	
Цэвэр, бохир усны зардал	176,035,718.63	
Үйл ажиллагааны зардал	<b>4,320,825,853.65</b>	<b>5,514,713,618.14</b>
Эм	4,066,061,720.65	5,310,495,011.14
Хоол	254,764,133.00	204,218,607.00
Бусад бараа үйлчилгээний зардал	<b>3,315,452,192.89</b>	<b>4,150,940,140.73</b>
Бичиг хэргийн материал	50,734,858.99	61,440,001.56
Тээвэр, шатахууны зардал	33,117,550.00	62,824,326.00
Шуудан холбооны зардал	10,000,000.00	16,005,225.88
Хог хаягдал, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	166,623,702.00	176,385,560.42
БҮТЭЗ	123,562,105.00	18,461,700.00
Бараа материал акталсны зардал	115,044,332.76	234,412,458.66
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	16,061,000.00	8,295,005.00
Бараа үйлчилгээний бусад зардал	23,717,824.64	30,339,800.00
Банкны үйлчилгээний хураамж		377,000.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	131,988,002.00	531,241,206.79
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,800,000.00	11,333,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	396,726.00	288,198.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00
Маягт хэвлүүлэх зардал	700,000.00	4,137,800.00
Багаж, техник, хэрэгсэл	88,888,045.00	141,364,811.24
Урсгал засварын зардал	246,034,305.00	109,148,060.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,833,835.00	7,977,550.00
Газрын төлбөр	612,162.00	1,416,990.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,691,000.00	6,806,000.00
Элэгдлийн зардал	2,297,536,744.50	2,728,575,447.18
<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>250,746,789.00</b>	<b>632,718,761.42</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	199,157,289.00	411,159,705.42
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	51,589,500.00	221,559,056.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>19,461,693,747.23</b>	<b>21,652,460,174.27</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>10,780,231,510.47</b>	<b>(436,752,611.08)</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>		
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>		
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>	<b>1,968,866,754.16</b>	<b>691,511,525.78</b>
Үнэ төлбөргүй гарсан зардал	8,034,180.00	
Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	8,932,950.15	11,809,550.25
Үнэ төлбөргүй гарсан зардал- Бараа материал	1,951,899,624.01	679,701,975.53
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>(1,968,866,754.16)</b>	<b>(691,511,525.78)</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>8,811,364,756.31</b>	<b>(1,128,264,136.86)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>Татаас, санхүүжилтийн орлого</b>	<b>14,955,502,517.21</b>	<b>16,230,999,230.16</b>
Нийгмийн даатгалын сангаас	14,955,502,517.21	16,230,999,230.16
Эрүүл мэндийн даатгалын сангаас	14,955,502,517.21	16,230,999,230.16
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>1,254,846,125.37</b>	<b>1,899,249,924.46</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхжүүих	1,068,661,221.37	948,064,484.80
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	186,184,904.00	951,185,439.66
Түрээсийн орлого		29,978,412.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>16,210,348,642.58</b>	<b>18,160,227,566.62</b>
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>11,235,062,466.52</b>	<b>11,819,199,286.00</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>10,102,229,786.30</b>	<b>10,450,716,486.00</b>
Цалин	6,077,498,176.15	5,964,282,272.74
Цалингийн тусгай нэмэгдлүүд	2,178,910,627.70	1,996,420,877.01
Унаа хоолны хөнгөлөлт	1,043,241,576.36	1,529,305,450.31
Урамшуулал	802,579,406.09	960,707,885.94
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>1,132,832,680.22</b>	<b>1,368,482,800.00</b>
Тэтгэврийн даатгал	792,207,800.00	923,516,500.00
Тэтгэмжийн даатгал	78,366,200.00	111,241,600.00
ҮОМШӨ-ний даатгал	39,183,100.00	55,620,800.00
Ажилгүйдлийн даатгал	39,183,100.00	55,620,800.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	183,892,480.22	222,483,100.00
<b>Бараа, үйлчилгээний урсгал зардал</b>	<b>4,467,762,625.54</b>	<b>5,824,462,972.56</b>
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	<b>3,675,858,765.90</b>	<b>4,489,434,321.10</b>
Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	3,425,603,895.90	4,316,571,971.10
Хоол, хүнс	250,254,870.00	172,862,350.00
Бусад бараа үйлчилгээний зардал	<b>791,903,859.64</b>	<b>1,335,028,651.46</b>
Бичиг хэргийн материал	39,052,145.00	45,588,348.55
Тээвэр, шатахууны зардал	27,862,450.00	63,864,326.00
Шуудан холбооны зардал	10,000,000.00	16,005,225.88
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	124,093,000.00	116,400,340.00
БҮТЭЗ	41,631,905.00	34,496,240.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	16,061,000.00	8,969,885.00
Бараа үйлчилгээний бусад зардал	31,084,224.64	31,479,400.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	58,307,300.00	6,695,000.00
Банкны үйлчилгээний хураамж		377,000.00
Маягт хэвлүүлэх зардал	9,069,000.00	10,357,950.00
Багаж техник хэрэгсэл	94,293,045.00	331,186,161.24
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,615,835.00	14,743,000.00
Урсгал засварын зардал	180,966,565.00	38,128,600.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	133,069,002.00	592,116,586.79
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	13,600,000.00	11,333,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	396,726.00	288,198.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,079,500.00	11,472,400.00
Газрын төлбөр	612,162.00	1,416,990.00
<u>Урсгал шилжүүлэг</u>	<b>250,746,789.00</b>	<b>632,718,761.42</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	199,157,289.00	411,159,705.42
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	51,589,500.00	221,559,056.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)</b>	<b>15,953,571,881.06</b>	<b>18,276,381,019.98</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>256,776,761.52</b>	<b>(116,153,453.36)</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(IV)</b>	-	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	527,495,755.00	27,426,700.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V)</b>	<b>527,495,755.00</b>	<b>27,426,700.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)</b>	<b>(527,495,755.00)</b>	<b>(27,426,700.00)</b>
<b>САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)</b>	-	-
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)</b>	<b>(270,718,993.48)</b>	<b>(143,580,153.36)</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>521,400,579.55</b>	<b>250,681,586.07</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>250,681,586.07</b>	<b>107,101,432.71</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,084,344,428.61	7,636,423,361.40	11,595,371,454.97	23,316,139,244.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга			1.00	1.00
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>4,084,344,428.61</b>	<b>7,636,423,361.40</b>	<b>11,595,371,455.97</b>	<b>23,316,139,245.98</b>
Тайлант үеийн үр дүн			8,811,364,756.31	8,811,364,756.31
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>4,084,344,428.61</b>	<b>7,636,423,361.40</b>	<b>20,406,736,212.28</b>	<b>32,127,504,002.29</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга			220,436.38	220,436.38
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>4,084,344,428.61</b>	<b>7,636,423,361.40</b>	<b>20,406,956,648.66</b>	<b>32,127,724,438.67</b>
Тайлант үеийн үр дүн			(1,128,264,136.86)	(1,128,264,136.86)
<b>2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>4,084,344,428.61</b>	<b>7,636,423,361.40</b>	<b>19,278,692,511.80</b>	<b>30,999,460,301.81</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татаас, санхүүжилтийн орлого</b>	<b>15,944,133,400.00</b>	<b>16,230,999,230.16</b>	<b>(286,865,830.16)</b>	<b>101.8</b>
<b>Нийгмийн даатгалын сангаас</b>	<b>15,944,133,400.00</b>	<b>16,230,999,230.16</b>	<b>(286,865,830.16)</b>	<b>101.8</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,944,133,400.00	16,230,999,230.16	(286,865,830.16)	101.8
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>2,172,309,500.00</b>	<b>1,929,228,336.46</b>	<b>243,081,163.54</b>	<b>88.8</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	945,147,000.00	978,042,896.80	(32,895,896.80)	103.5
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,227,162,500.00	951,185,439.66	275,977,060.34	77.5
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>18,116,442,900.00</b>	<b>18,160,227,566.62</b>	<b>(43,784,666.62)</b>	<b>100.2</b>
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>11,819,199,300.00</b>	<b>11,819,199,286.00</b>	<b>14.00</b>	<b>100.0</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>10,450,716,500.00</b>	<b>10,450,716,486.00</b>	<b>14.00</b>	<b>100.0</b>
Цалин	6,894,775,900.00	5,964,282,272.74	930,493,627.26	86.5
Цалингийн тусгай нэмэгдлүүд	1,704,584,400.00	1,996,420,877.01	(291,836,477.01)	117.1
Унаа хоолны хөнгөлөлт	793,806,400.00	1,529,305,450.31	(735,499,050.31)	192.7
Урамшуулал	1,057,549,800.00	960,707,885.94	96,841,914.06	90.8
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>1,368,482,800.00</b>	<b>1,368,482,800.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Тэтгэврийн даатгал	923,516,500.00	923,516,500.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	111,241,600.00	111,241,600.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	55,620,800.00	55,620,800.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	55,620,800.00	55,620,800.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгалын хураамж	222,483,100.00	222,483,100.00	-	100.0
<b>Бараа, үйлчилгээний урсгал зардал</b>	<b>5,912,313,800.00</b>	<b>5,851,889,672.56</b>	<b>60,424,127.44</b>	<b>99.0</b>
<b>Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал</b>	<b>4,439,218,700.00</b>	<b>4,499,324,321.10</b>	<b>(60,105,621.10)</b>	<b>101.4</b>
Эм	4,267,555,300.00	4,326,461,971.10	(58,906,671.10)	101.4
Хоол	171,663,400.00	172,862,350.00	(1,198,950.00)	100.7
<b>Бусад бараа үйлчилгээний зардал</b>	<b>1,473,095,100.00</b>	<b>1,352,565,351.46</b>	<b>120,529,748.54</b>	<b>91.8</b>
Бичиг хэргийн материал	45,613,000.00	45,588,348.55	24,651.45	99.9
Тээвэр, шатахууны зардал	117,987,300.00	63,864,326.00	54,122,974.00	54.1
Шуудан холбооны зардал	10,000,000.00	16,005,225.88	(6,005,225.88)	160.1
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	111,002,000.00	116,400,340.00	(5,398,340.00)	104.9
<b>БҮТЭЭ</b>	<b>38,478,600.00</b>	<b>34,496,240.00</b>	<b>3,982,360.00</b>	<b>89.7</b>
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	10,899,000.00	8,969,885.00	1,929,115.00	82.3
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	8,000,000.00	6,695,000.00	1,305,000.00	83.7

Банкны үйлчилгээний хураамж	544,500.00	377,000.00	167,500.00	69.2
Маягт хэвлүүлэх зардал	10,125,900.00	10,357,950.00	(232,050.00)	102.3
Багаж, техник хэрэгсэл	350,301,600.00	348,722,861.24	1,578,738.76	99.5
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	16,667,000.00	14,743,000.00	1,924,000.00	88.5
Урсгал засварын зардал	40,000,000.00	38,128,600.00	1,871,400.00	95.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	636,491,600.00	592,116,586.79	44,375,013.21	93.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	13,600,000.00	11,333,000.00	2,267,000.00	83.3
Даатгалын үйлчилгээ	473,300.00		473,300.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	402,600.00	288,198.00	114,402.00	71.6
Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00	-	100.0
Газрын төлбөр	5,609,000.00	1,416,990.00	4,192,010.00	25.3
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,667,000.00	11,472,400.00	194,600.00	98.3
Бараа үйлчилгээний бусад зардал	45,122,700.00	31,479,400.00	13,643,300.00	69.8
<b>Урсгал зардлын дүн</b>	<b>707,969,100.00</b>	<b>632,718,761.42</b>	<b>75,250,338.58</b>	<b>89.4</b>
Бусад урсгал шилжүүлэг	<b>707,969,100.00</b>	<b>632,718,761.42</b>	<b>75,250,338.58</b>	<b>89.4</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	486,379,200.00	411,159,705.42	75,219,494.58	84.5
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	221,589,900.00	221,559,056.00	30,844.00	100.0
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>18,439,482,200.00</b>	<b>18,303,807,719.98</b>	<b>135,674,480.02</b>	<b>99.3</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		250,681,586.07	(250,681,586.07)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		107,101,432.71	(107,101,432.71)	

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагнал, тооцоололтой холбоотой 129,462.1 мянган төгрөгийн 4 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тус эмнэлгийн дансанд бүртгэлтэй газар эзэмших эрхийг нотлох баримтгүйгээр бууруулж бүртгэсэн.	1	43,676.5			1	43,676.5	1	43,676.5				
Үнэ төлбөргүй ирсэн бараа материал, үндсэн хөрөнгийг санхүүгийн үр дүнгийн тайланд хий бичилт хийж нэмэгдүүлсэн, үндсэн хөрөнгийн элэгдлийг бууруулж бүртгэсэн.	1	66,498.1			1	66,498.1	1	66,498.1				
ХЧТА тэтгэмжийг буруу бүртгэж өглөгт илүү бүртгэсэн	1	5,000.0			1	5,000.0	1	5,000.0				
ЭМЯ-наас ирсэн хиймэл оюун ухаанд суурилсан рентгений компьютерийг орлогод аваагүй.	1	14,287.5	1	14,287.5			1	14,287.5				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>129,462.1</b>	<b>1</b>	<b>14,287.5</b>	<b>3</b>	<b>115,174.6</b>	<b>4</b>	<b>129,462.1</b>				

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 934,954.8 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 7 албан шаардлага хүргүүллээ.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эмийн зардал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлаас бараа материал, үндсэн хөрөнгө худалдан авсан ч орлогод аваагүй, шууд зардалд бичсэн байна.	1	183,024.8			1	183,024.8				
Эмийн зардлаас аж ахуйн болон хүнс, хангамжийн материал, шатахуун, тоног төхөөрөмж, ахмадын өдөрлөгийн төлбөр шилжүүлсэн.	1	445,744.1			1	445,744.1				
Урсгал засварын зардал гаргасан боловч ямар ажил үйлчилгээ хийсэн тухай тайлан байхгүй, гэрээ дүгнэсэн актгүй, дэмжин нотлох анхан шатны баримтгүй, шууд эмийн зардал болон бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардалд хааж бичсэн.	1	16,151.8			1	16,151.8				
Худалдан авах ажиллагааны хууль, журмыг мөрдөөгүй, түрээслэгч эмийн сангаас эмнэлгийн хэрэгсэл жижиглэн худалдан авалт хийсэн.	1	19,000.0			1	19,000.0				
Бараа материалын дансанд эм, эмнэлгийн хэрэгслийн шаардлагагүй нөөц үүсгэсэн.	1	151,224.5							1	151,224.5
Эмийн зардлаас даргын гадаад томилолтын зардал гаргасан, мөнгөн урьдчилгааны тайлан хийгээгүй, тооцоо бодоогүй, эмийн зардалд хаасан байна.	1	5,790.0			1	5,790.0				
Анхан шатны дэмжин нотлох баримтгүйгээр байгууллагын ажилчдын данс руу 6 настнуудын шүд, зүрх, нүдний үзлэгийн төлбөр гэж шилжүүлсэн	1	114,019.6			1	114,019.6				
Дүн	7	934,954.8			6	783,730.3			1	151,224.5

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийцлийн аудитын асуудлаар 54,207.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Үндсэн хөрөнгийн дансанд 1975 онд ашиглалтад орсон элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, одоогоор иргэдэд ашиглуулж байгаа БГД-ийн 20 дугаар хороо Толгойт дахь хүүхдийн эмнэлгийн байрыг зориулалтын дагуу эзэмшиж ашиглаагүй, маргаантай асуудлыг шийдвэрлэх талаар ажил зохион байгуулаагүй, өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	54,207.0			1	54,207.0		
Дүн	1	54,207.0			1	54,207.0		